

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д ДААЛГАХ нь:

2.1. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд, тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагуудад тогтоолыг танилцуулах, сурталчилах, нэгдсэн удирдлага, бодлогын зохицуулалтаар хангах, хяналт тавих, хамралтыг эрчимжүүлэх, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2. Даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг үзүүлэх эмнэлзүйн заавар, удирдамж, товлол, давтамж, зохион байгуулалт, холбогдох бусад журамд шаардлагатай үед нэмэлт, өөрчлөлтийг оруулах;

2.3. Даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын цахим системийг хөгжүүлж, холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, эрүүл мэндийн даатгалын цахим системд бодит цагийн горимоор холбох арга хэмжээг авч ажиллах;

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг хавсран гүйцэтгэгч (М. Нармандах)-т ДААЛГАХ нь:

3.1. Даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхи бүхий эрүүл мэндийн байгууллагыг сонгож, даатгалын гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2. Иргэд, даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлэл хүргэх, сурталчилах ажлыг шуурхай зохион байгуулах;

3.3. Эрүүл мэндийн даатгалын цахим програм хангамжинд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулах;

3.4. Эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг холбогдох эрх зүйн хүрээнд худалдан авах, нэхэмжлэлийг бодит цагийн горимоор хүлээн авч, чанарын болон төлбөрийн хяналтыг үндэслэн санхүүжилтийг олгох;

3.5. Даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр үнэлгээ хийж, үр дүнг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлд танилцуулах;

4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны програм, цахим системд шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийж, бодит цагийн горимд бүрэн шилжүүлэх, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй хүргэхийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

6. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2023 оны 11-р сарын 27-ны өдрийн 10 дугаар тогтоол, хүчингүй болсонд тооцсугай.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн ажлын алба /Ц. Сарантуяа/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Т. МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ (цаашид “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц” гэх)-нд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн, тогтоосон товлолт хугацаанд хамруулах, зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгуулагчийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо нь хүний нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан тогтоосон өвчнийг эрт үед нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх товлол баталсан төрийн захиргааны төв байгууллагын бодлого, шийдвэртэй уялдаж, товлол, давтамжид өөрчлөлт орсон тохиолдолд хүчин төгөлдөр тушаалыг даган мөрдөнө.

1.3. Эрүүл мэндийн байгууллага нь даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамаарах үзлэг, оношилгоо, шинжилгээг үзүүлэхдээ тусламж, үйлчилгээ үзүүлж эхэлсэн болон дууссан хугацааг иргэний регистрийн дугаараар бүртгэж, хурууны хээгээр баталгаажуулна.

1.4. Энэ тогтоолоор батлагдсан товлосон хугацаанд хийгдэж буй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц нь төлбөртэй тусламж, үйлчилгээнд хамаарахгүй бөгөөд эрүүл мэндийн байгууллага нь уг тусламж, үйлчилгээг даатгуулагчаас аливаа төлбөр авахгүйгээр, харьяалал харгалзахгүй, чирэгдэлгүй үзүүлнэ. Уг тусламж, үйлчилгээтэй холбогдох төлбөр авсан нь нотлогдвол гэрээ цуцлах үндэслэл болно.

Хоёр. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын төрөл ба зохион байгуулалт

2.1. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц нь “Сургуульд суурилсан”- эрт илрүүлэг, хавдрын эрт илрүүлэг гэсэн хоёр үндсэн хэсэгтэй. Сургуульд суурилсан эрт илрүүлэг болох “6 настан”, “12 настан”, “15 настан” багцад хамаарах даатгуулагч нь харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдана. Хавдрын эрт илрүүлгийн багцад насанд хүрсэн даатгуулагч эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн товлолийн дагуу хамрагдах бөгөөд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн урилга, зохицуулалтайгаар эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагаас сонгон, эрт илрүүлгийн багцад хамрагдана. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь тухай бүр нэхэмжлэлд үндэслэн хяналт тавьж, санхүүжүүлнэ.

2.2. Даатгуулагч нь дараах үүрэг, оролцоотой байна. Үүнд:

2.2.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ бүрэн төлж, даатгуулсан байх;

2.2.2. Харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж, эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээнд хамрагдан, нэгдсэн бүртгэлд хамрагдах;

2.2.3. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын лавлагаа шатлалд хамаарах тусламж, үйлчилгээг үзүүлэхээр эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагаас сонгон үйлчлүүлэх;

2.2.4. Сонгосон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагатай холбогдон урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын цаг товлох, товлосон цагт тусламж, үйлчилгээнд хамрагдах, тухайн хугацаанд хамрагдах боломжгүй тохиолдолд өөрийн боломжит цагийг дахин товлох;

2.2.5. Хавдрын төрлүүдээс хамаарч хамрагдах оношилгоо, шинжилгээ ялгаатай тул нас, хүйс, эрсдлийн үнэлгээнд үндэслэн тогтоосон оношилгоо шинжилгээнд товллын дагуу идэвхтэй хамрагдах;

2.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг даатгуулагчид үзүүлэх зохион байгуулалтад дараах үүрэг, оролцоотой байна. Үүнд:

2.3.1. Эрт илрүүлэгт хамрагдах иргэдийн бүртгэл, мэдээллийг эрт илрүүлгийн багц бүрээр нарийвчлан гаргах

2.3.2. Хавдрын эрт илрүүлэгт хамрагдах насны бүлгийн иргэдийн холбогдох эрсдлийг үнэлж, эрсдэл өндөртэй иргэдээс эхлэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн оношилгоо шинжилгээнд хамруулах

2.3.3. Эмнэлгээр үйлчлүүлдэггүй, өмнө нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн оношилгоо, шинжилгээнд хамрагдаж байгаагүй иргэдийг хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.3.4. Даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдахыг урьсан цаасан болон цахим урилгыг /эсхүл утсаар мэдэгдэх/ энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамруулахаар тогтоосон товлолт насанд хүрсэн сард нь багтаан хүргүүлэх;

2.3.5. Урилга илгээгдсэн иргэнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдах товлолт өдрөөс 1-3 өдрийн өмнө сануулах /утас, мессеж/;

2.3.6. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц, түүний зохион байгуулалт, хаана, хэрхэн хамрагдах талаар мэдээллээр хангаж, гэрээ бүхий лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагаас сонголт хийхэд нь туслах;

2.3.7. Даатгуулагчийн сонгосон эрүүл мэндийн байгууллага руу даатгуулагчийн холбогдох мэдээллийг хүргүүлэх;

2.3.8. Лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын үзлэг, оношилгоо, шинжилгээний хариу дүгнэлтийг авч, харьяалах хүн амын нэгдсэн мэдээллийн бааз үүсгэж, дүн шинжилгээ хийх, даатгуулагчид болон холбогдох төрийн захиргааны байгууллагад мэдээлэх;

2.3.9. Сургуульд суурилсан эрт илрүүлгийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах шүд хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгээр нэмэлт гэрээ байгуулна.

2.4. Гэрээт лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллага нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг даатгуулагчид үзүүлэх зохион байгуулалтад дараах үүрэг, оролцоотой байна. Үүнд:

2.4.1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн мэдээлэл дээр үндэслэн даатгуулагчтай холбогдон цаг товлох, тухайн хугацаанд хамрагдах боломжгүй тохиолдолд боломжит цагийг дахин товлох;

2.4.2. Сонгон ирсэн даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын тусламж үйлчилгээг холбогдох удирдамжийг баримтлан цогцоор нь үзүүлэх, шаардлагатай бол бусад чадамж бүхий байгууллагатай гэрээлж, даатгуулагчдыг санхүүгийн болон цаг хугацааны хүндрэлд оруулахгүй байх;

2.4.3. Даатгуулагчид үзүүлэх урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг үзүүлж эхэлснээс дуусах хүртэл нь ажлын 20 хоногийн хугацаанд багтаах;

2.4.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдах даатгуулагчид цаг олгох, тусламж, үйлчилгээг үзүүлэх зохион байгуулалтыг үндсэн тусламж, үйлчилгээнээс ялгаатайгаар зохион байгуулах;

2.4.5. Даатгуулагчийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц дахь эрсдэлийн үнэлгээ, биеийн ерөнхий үзлэгийг хийхээс гадна үзлэгийн мэдээлэл, оношилгоо, шинжилгээний хариу болон дүгнэлтийг эрүүл мэндийн даатгалын цахим системээс нэг хувь хэвлэн, эрүүл мэндийн байгууллагын

болон эмчийн тамга тэмдгээр баталгаажуулан даатгуулагчид заавал өгөх эсвэл цахим шуудангаар /скайнердаж/ илгээх;

2.4.6. Даатгуулагчийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн багц дахь үзлэгийн мэдээлэл, оношилгоо, шинжилгээний хариу болон дүгнэлтийг анх илгээсэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд цахим хэлбэрээр мэдээлэх;

2.4.7. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын зардлын төлбөрийн нэхэмжлэлийг гэрээнд заасан хугацаанд тавьсан шаардлагын дагуу эрүүл мэндийн даатгалын байгууллагад илгээх;

2.4.8. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын талаарх мэдээллийг ил тод, ойлгомжтой хэлбэрээр ханын самбар болон цахим хуудсанд байршуулан, даатгуулагчийг үнэн зөв мэдээллээр хангах;

2.4.9. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдсан даатгуулагчдад өвчин эмгэг илэрсэн тохиолдолд цаг алдалгүй холбогдох эрүүл мэндийн байгууллагад хандах, зөвлөх үйл ажиллагааг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон тухайн багцыг үзүүлсэн лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагууд хариуцана.

2.4.10. Хэрэв даатгуулагч урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдахаас 20 хоногийн дотор лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц, өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний багц /Улаан хоолой ходоодны дуран гэх мэт/-ын тусламж, үйлчилгээ авсан бол урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн багцад орсон оношилгоо, шинжилгээг давхардуулан хийхгүй бөгөөд өмнөх оношилгоо, шинжилгээний үр дүнг ашиглана.

2.5.11. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний дүгнэлтийг үндэслэн даатгуулагчийг дараагийн лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд илгээхдээ эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журмыг баримтална.

2.5.12. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний дүгнэлтийг үндэслэн даатгуулагчийг тухайн эрүүл мэндийн байгууллагад эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд шууд илгээж болно.

2.5. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг даатгуулагчид үзүүлэх зохион байгуулалтад дараах үүрэг, оролцоотой байна. Үүнд:

2.5.1. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын талаарх мэдээллийг өөрийн цахим хуудаст ил тод, ойлгомжтой хэлбэрээр

байршуулж, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, аппликейшнээр сурталчилж даатгуулагчийг мэдээллээр хангах;

2.5.2. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг үзүүлэх лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагыг сонгох, сонгогдсон эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулах;

2.5.3. Гэрээт лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад чанар болон төлбөрийн хяналт тогтмол тавих;

2.5.4. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй чанар болон төлбөрийн хяналтын шалгуур хангасан тохиолдлыг санхүүжүүлэх;

2.5.5. Хэрэв даатгуулагчид үндсэн шинжилгээ, оношилгоо өөрчлөлттэй, эрсдэлийн үнэлгээ өндөр гарсан тохиолдолд холбогдох нэмэлт шинжилгээ, оношилгоог хийсэн эсэхэд хяналт тавьж холбогдох зардлыг олгох;

2.5.6. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдсан даатгуулагчийн зардлын мэдээллийг даатгуулагч бүрээр шалгаж, зардлын төлбөрийг холбогдох журмын дагуу хянаж, гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх;

2.5.7. Даатгуулагчаас ирүүлсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагатай холбоотой тусламж, үйлчилгээний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

Гурав. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын тохиолдлын тоог тооцох, зардлын төлбөрийг санхүүжүүлэх

3.1. Журмын хавсралтад заасан удирдамжийг баримтлан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын зардлын төлбөрийг санхүүжүүлнэ.

3.2. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид цогцоор нь үзүүлсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг нэг тохиолдолд тооцон, даатгалын сангаас гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ.

3.3. Даатгуулагч тухайн насанд товлогдсон урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн багцад тухайн товлолын дагуу хоёр жилд нэг удаа хамрагдах бөгөөд өөр байгууллагад дахин хийлгэсэн тохиолдолд зөвхөн эхний эрүүл мэндийн байгууллагын тохиолдлыг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлнэ.

3.4. Даатгуулагч энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан товлот насанд багтаан холбогдох урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн багцад хамрагдах бөгөөд товлот нас өнгөрсөн тохиолдолд нөхөн хамрагдахгүй. Нөхөн хамрагдалтыг даатгалын сангаас санхүүжүүлэхгүй.

3.5. Эрүүл мэндийн байгууллага нь ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг хуурамчаар нэхэмжилсэн нь чанар, төлбөрийн хяналтаар илэрсэн бол санхүүжүүлэхгүй бөгөөд гэрээний дагуу хариуцлага ногдуулна.

3.6. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдаж буй хугацаанд яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээгээр дамжин хэвтүүлэн эмчилсэн тохиолдлоос бусад хэвтүүлэн эмчилсэн тохиолдлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй.

3.7. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хариуцан хийсэн бага болон сургуулийн насны хүүхдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц болон насанд хүрэгчдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгт урьдчилан мэдэгдэх, урих, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагатай холбох, зохион байгуулах үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээнд багтсан тул нэмэлтээр санхүүжүүлэхгүй.

3.8. Хэрэв даатгуулагч багц доторх оношилгоо, шинжилгээг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдахаас нэг сарын дотор хийлгэсэн буюу түүнийг ЭМД-ын бусад багцаас санхүүжүүлсэн, эсхүл эрт илрүүлгийн явцад өөрөө хийлгэхээс татгалзсан, эсхүл эрт илрүүлгийн явцад биеийн байдлаас хамаарч хийлгэх боломжгүй байсан зэрэг тохиолдолоос шалтгаалж дутуу үзүүлсэн бол нотлох баримтыг нэхэмжлэлд хавсаргах бөгөөд нэхэмжлэлийг чанар, төлбөрийн хяналтын журмын дагуу хянаж, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жишиг хэмжээнд заасан үнийг баримтлан уг оношилгоо, шинжилгээний зардлыг тухайн багцын төлбөрөөс хасч, үлдэх санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад олгоно.

3.9. Хэрэв энэхүү журмын 3.8-д зааснаас бусад тохиолдолд тухайн багцад орсон оношилгоо, шинжилгээг хийгээгүй тохиолдолд багцын санхүүжилтийг олгохгүй.

3.10. Жирэмсэн болон ураг, нярайн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн багц нь лавлагаа шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээний багц, холбогдох оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээнд багтсан тул энэхүү багц, журмаар зохицуулахгүй.

Дөрөв. Бусад

4.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтан, даатгуулагчид хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Журамд тусгагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн даатгалын гэрээгээр зохицуулна.

Тав. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын нэгж тохиолдлыг тооцох, түүний зардлын бүрэлдэхүүн, төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зохицуулалт

Эрүүл мэндийн даатгалын сангаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг санхүүжүүлэх нэгж тохиолдолд хамаарах тусламж, үйлчилгээнүүд, хязгаарлах нөхцөл, түүний зардлын бүрэлдэхүүн

Тусламж үйлчилгээний төрөл	Нэгж тохиолдлыг тооцох	Нэгж тохиолдлыг хязгаарлах нөхцөл	Нэгж тохиолдлын зардлын бүрэлдэхүүн	
Багц 1: “6 настан”-ы эрт илрүүлэг	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас товлосон хугацаанд урьдчилан мэдэгдсэний дагуу эрүүл мэндийн байгууллагад ирж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц дахь тусламж, үйлчилгээнд бүрэн хамрагдсаныг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Энэ багцад доорх тусламж, үйлчилгээ багтана.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ерөнхий үзлэг 2. Хэмжилт: Өндөр, жин бүсэлхийн тойрог, 3. Хараа сонсгол 4. Шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө 5. Зүрхний цахилгаан бичлэг 	<p>Зөвхөн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд хийгдэнэ.</p>	<p>“6 настан”-ы эрт илрүүлгийн багцын зардлын бүрэлдэхүүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Даатгуулагчийг товлолт хугацаанд дуудах, урилга өгөх, дүгнэлт бичиж зөвлөгөө өгөх болон зохион байгуулах үйл ажиллагааны зардал 2. Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлэг (ерөнхий үзлэг, өсөлтийн үнэлгээ өндөр, жин бүсэлхийн тойрог, хараа, сонсгол) 3. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн үзлэг (шүдний цоорол, гаж хөгжлийн үнэлгээ, эрүүл ахуйн зөвлөгөө) 4. Зүрхний цахилгаан бичлэгийн зардал 5. Эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.. 	
	<p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:</p>	<p>Энэ багцад багтсан тусламж, үйлчилгээнд даатгуулагчийг хамруулах үйл ажиллагаа нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ба ерөнхий үзлэг, хэмжилт, хараа сонсголыг үнэлэхтэй холбоотой зардал нь анхан шатны нэг иргэнээр тооцсон төлбөрт багтсан тул давхар санхүүжилт олгохгүй.</p> <p>Зүрхний цахилгаан бичлэгийг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх оношилгоо, шинжилгээний тарифаар санхүүжүүлнэ.</p> <p>Шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөөг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.</p>		
	<p>Зохицуулалт:</p>	<p>Энэхүү багц нь зөвхөн 6 настанд хийгдэнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага энэ багцын тусламж, үйлчилгээг боловсролын байгууллагын удирдлагатай тохиролцсоны дагуу боловсролын байгууллага дээр нь очиж хэрэгжүүлж болно.</p>		

Багц 2: “12 настан”-ы эрт илрүүлэг	<p>Эрүүл мэндийн байгууллагаас товлосон хугацаанд урьдчилан мэдэгдсэний дагуу эрүүл мэндийн байгууллагад ирж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц дахь тусламж, үйлчилгээнд бүрэн хамрагдсаныг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Энэ багцад доорх тусламж, үйлчилгээ багтана.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ерөнхий үзлэг 2. Хэмжилт: Өндөр, жин бүсэлхийн тойрог, 3. Хараа сонсгол 4. Шүдний урьдчилан сэргийлэх үзлэг 5. Хооллолтын асуумж, зөвлөгөө 	<p>Зөвхөн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд хийгдэнэ.</p>	<p>“12 настан”-ы эрт илрүүлгийн багцын зардлын бүрэлдэхүүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Даатгуулагчийг товлолт хугацаанд дуудах, урилга өгөх, дүгнэлт бичиж зөвлөгөө өгөх болон зохион байгуулах үйл ажиллагааны зардал, 2. Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлэг (ерөнхий үзлэг, өсөлтийн үнэлгээ өндөр, жин бүсэлхийн тойрог, хараа, сонсгол) 3. Амны хөндийн эрүүл мэндийн үзлэг (шүдний цоорол, гаж хөгжлийн үнэлгээ, эрүүл ахуйн зөвлөгөө) 4. Хооллолтын асуумж, зөвлөгөө 5. Эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна. 	
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:	<p>Энэ багцад багтсан тусламж үйлчилгээнд даатгуулагчийг хамруулах үйл ажиллагаа нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ба үүнтэй холбоотой зардлыг анхан шатны нэг иргэнээр тооцсон төлбөрт багтсан тул давхар санхүүжилт олгохгүй.</p> <p>Зүрхний цахилгаан бичлэгийг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх оношилгоо, шинжилгээний тарифаар санхүүжүүлнэ.</p> <p>Шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөөг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.</p>		
	Зохицуулалт:	<p>Энэхүү багц нь зөвхөн 12 настанд хийгдэнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага энэ багцын тусламж, үйлчилгээг боловсролын байгууллагын удирдлагатай тохиролцсоны дагуу боловсролын байгууллага дээр нь хүрч очин хэрэгжүүлж болно.</p>		
Багц 3: “15 настан”-ы эрт илрүүлэг	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас товлосон хугацаанд урьдчилан мэдэгдсэний дагуу лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад ирж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн авсныг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Энэ багцад доорх оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээ багтана.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ерөнхий үзлэг 	<p>Зөвхөн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд хийгдэнэ.</p>	<p>“15 настан”-ы эрт илрүүлгийн багцын зардлын бүрэлдэхүүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Даатгуулагчийг товлолт хугацаанд дуудах, урилга өгөх, дүгнэлт бичиж зөвлөгөө өгөх болон зохион байгуулах үйл ажиллагааны зардал, 2. Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлэг (ерөнхий үзлэг, өсөлтийн үнэлгээ өндөр, жин бүсэлхийн тойрог, хараа, сонсгол) 	

	<ol style="list-style-type: none"> 2. Хэмжилт: Өндөр, жин бүсэлхийн тойрог, 3. Хараа сонсгол 4. Сэтгэлзүйн сорил, зөвлөгөө 5. Сүрьеэгийн эрсдэлийн үнэлгээ 6. ХДХВ илрүүлэх хурдавчилсан шинжилгээ 		<ol style="list-style-type: none"> 3. Сэтгэлзүйн сорил, зөвлөгөө 4. Сүрьеэгийн эрсдэлийн үнэлгээ 5. ХДХВ илрүүлэх хурдавчилсан шинжилгээ 6. Эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна. 	
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:	<p>Энэ багцад багтсан тусламж үйлчилгээнд даатгуулагчийг хамруулах үйл ажиллагаа нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ба үүнтэй холбоотой зардлыг анхан шатны нэг иргэнээр тооцсон төлбөрт багтсан тул давхар санхүүжилт олгохгүй.</p> <p>ХДХВ илрүүлэх хурдавчилсан шинжилгээний зардлыг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.</p>		
	Зохицуулалт	<p>Энэхүү багц нь зөвхөн 15 настанд хийгдэнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага энэ багцын тусламж, үйлчилгээг боловсролын байгууллагын удирдлагатай тохиролцсоны дагуу боловсролын байгууллага дээр нь хүрч очин хэрэгжүүлж болно.</p>		
Багц 4: Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас товлосон хугацаанд урьдчилан мэдэгдсэний дагуу лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад ирж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн авсныг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Энэ багцад дараах оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээ багтана.</p> <p>А Анхан шатны эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах 2. В вирус илрүүлэх хурдавчилсан сорил 3. С вирус илрүүлэх хурдавчилсан сорил 4. В эсвэл С вирус илэрсэн тохиолдолд эмчийн үзлэг хийж, хяналтад аван, дараагийн шатлалд илгээх <p>Б. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. В вирус ачаалал үзэх шинжилгээ 2. С вирус ачаалал үзэх шинжилгээ 3. Хэвлийн хэт авиа 4. Элэгний үйл ажиллагаа: Биохими /АСАТ, АПАТ, шууд билирубин/ 5. Цусанд АФП үзэх 		<p>Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй товлол, давтамжийн дагуу хийгдэнэ.</p>	<p>Энэ багцын зардлын бүрэлдэхүүнд хурдавчилсан оношлуур, урвалж бодис, лабораторийн зардал, эрсдэлийн үнэлгээ, эмчийн үзлэг, багцын дүгнэлт бичих, зөвлөгөө өгөх болон эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.</p>

	6. Эмчийн үзлэг, хяналт зөвлөгөө		
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:	Даатгуулагчийг товлोलт хугацаанд урьдчилан мэдэгдсэний, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагатай холбох асуудлыг зохион байгуулах ажил анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ба үүнтэй холбоотой зардлыг анхан шатны нэг иргэнээр тооцсон төлбөрт багтсан тул давхар санхүүжилт олгохгүй. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийх оношилгоо, шинжилгээний зардлыг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ. Багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн хийлгэсэн байна.	
Багц 5: Ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас товлосон хугацаанд урьдчилан мэдэгдсэний дагуу лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад ирж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн авсныг нэг тохиолдол гэж тооцно. Энэ багцад дараах оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээ багтана. А Анхан шатны эрүүл мэндийн байгууллага 1. Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах 2. Эрсдлийн үнэлгээ, улаан хоолой ходоодны дуранд илгээх 3. Лавлагаа шатлалын эмнэлгээс дурангийн шинжилгээний үр дүнг авч бүртгэлийг шинэчлэх Б. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага 1. Улаан хоолой, ходоодны дуран 2. Улаан хоолой ходоодны дуран ба эдийн шинжилгээ 3. Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө	Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй товлол, давтамжийн дагуу хийгдэнэ.	Энэ багцын зардлын бүрэлдэхүүнд хурдавчилсан оношлуур, урвалж бодис, лабораторийн зардал, эрсдэлийн үнэлгээ, эмчийн үзлэг, багцын дүгнэлт бичих, зөвлөгөө өгөх болон эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:	Даатгуулагчийг товлोलт хугацаанд урьдчилан мэдэгдсэний, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагатай холбох асуудлыг зохион байгуулах ажил анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ба үүнтэй холбоотой зардлыг анхан шатны нэг иргэнээр тооцсон төлбөрт багтсан тул давхар санхүүжилт олгохгүй. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийх оношилгоо, шинжилгээний зардлыг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ. Багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн хийлгэсэн байна.	
	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас товлосон хугацаанд урьдчилан мэдэгдсэний дагуу лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад ирж,	Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад хүчин	Энэ багцын зардлын бүрэлдэхүүнд хурдавчилсан оношлуур, урвалж бодис, лабораторийн зардал, эрсдэлийн үнэлгээ,

<p>Багц 6: Бүдүүн гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг</p>	<p>урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн авсныг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Энэ багцад дараах оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээ багтана.</p> <p>А. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах 2. Эрсдлийн үнэлгээ 3. Өтгөнд далд цус илрүүлэх хурдавчилсан сорил 4. Эрсдэлтэй иргэдийг бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээнд илгээх 5. Дурангийн шинжилгээний хариуг авч бүртгэлийг шинэчлэх <p>Б. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. Бүдүүн гэдэсний дуран 2. Бүдүүн гэдэсний дуран, эдийн шинжилгээ 3. Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө 	<p>төгөлдөр мөрдөгдөж буй товллол, давтамжийн дагуу хийгдэнэ.</p>	<p>эмчийн үзлэг, багцын дүгнэлт бичих, зөвлөгөө өгөх болон эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:</p>	<p>Даатгуулагчийг товллолт хугацаанд урьдчилан мэдэгдсэний, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагатай холбох асуудлыг зохион байгуулах ажил анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ба үүнтэй холбоотой зардлыг анхан шатны нэг иргэнээр тооцсон төлбөрт багтсан тул давхар санхүүжилт олгохгүй.</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийх оношилгоо, шинжилгээний зардлыг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.</p> <p>Багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн хийлгэсэн байна.</p>		
<p>Багц 7: Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг</p>	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас товлосон хугацаанд урьдчилан мэдэгдсэний дагуу лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад ирж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн авсныг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Энэ багцад дараах оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээ багтана.</p> <p>А. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах 2. Эсийн шинжилгээ ПАП тестийн сорьц авах 	<p>Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй товллол, давтамжийн дагуу хийгдэнэ.</p>	<p>Энэ багцын зардлын бүрэлдэхүүнд хурдавчилсан оношлуур, урвалж бодис, лабораторийн зардал, эрсдэлийн үнэлгээ, эмчийн үзлэг, багцын дүгнэлт бичих, зөвлөгөө өгөх болон эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.</p>

	<ol style="list-style-type: none"> 3. ПСР тестийн сорьц авах 4. Шинжилгээний хариуг авч бүртгэлийг шинэчлэх <p>Б. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүний папилома вирусын шинжилгээ 2. Умайн хүзүүний эсийн шинжилгээ 3. Кольпоскопи хийх 4. Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө 		
<p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:</p>	<p>Даатгуулагчийг товллолт хугацаанд урьдчилан мэдэгдсэний, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагатай холбох асуудлыг зохион байгуулах ажил анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ба үүнтэй холбоотой зардлыг анхан шатны нэг иргэнээр тооцсон төлбөрт багтсан тул давхар санхүүжилт олгохгүй. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийх оношилгоо, шинжилгээний зардлыг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ. Багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн хийлгэсэн байна.</p>		
<p>Багц 8: Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг</p>	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас товлосон хугацаанд урьдчилан мэдэгдсэний дагуу лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад ирж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн авсныг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Энэ багцад дараах оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээ багтана.</p> <p>А Анхан шатны эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах 2. Эрсдлийн үнэлгээ 3. Лавлагаа шатлалаас гарсан шинжилгээний хариуг авч бүртгэлийг шинэчлэх <p>Б. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөхний хэт авиан шинжилгээ 2. Маммографи 3. Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө 	<p>Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй товллолт, давтамжийн дагуу хийгдэнэ.</p>	<p>Энэ багцын зардлын бүрэлдэхүүнд хурдавчилсан оношлуур, урвалж бодис, лабораторийн зардал, эрсдэлийн үнэлгээ, эмчийн үзлэг, багцын дүгнэлт бичих, зөвлөгөө өгөх болон эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:</p>	<p>Даатгуулагчийг товллолт хугацаанд урьдчилан мэдэгдсэний, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагатай холбох асуудлыг зохион байгуулах ажил анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ба үүнтэй холбоотой зардлыг анхан шатны нэг иргэнээр тооцсон төлбөрт багтсан тул давхар санхүүжилт олгохгүй.</p>		

		<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийх оношилгоо, шинжилгээний зардлыг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ. Багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн хийлгэсэн байна.</p>	
<p>Багц 9: Уушигны хорт хавдрын эрт илрүүлэг</p>	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас товлосон хугацаанд урьдчилан мэдэгдсэний дагуу лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад ирж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн авсныг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Энэ багцад дараах оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээ багтана.</p> <p>А Анхан шатны эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах 2. Эрсдлийн үнэлгээ 3. Лавлагаа шатлалаас гарсан шинжилгээний хариуг авч бүртгэлийг шинэчлэх <p>Б. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага</p> <ol style="list-style-type: none"> 1. Бага тунт компьютер томографи 2. Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө 	<p>Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй товлол, давтамжийн дагуу хийгдэнэ.</p>	<p>Энэ багцын зардлын бүрэлдэхүүнд хурдавчилсан оношлуур, урвалж бодис, лабораторийн зардал, эрсдэлийн үнэлгээ, эмчийн үзлэг, багцын дүгнэлт бичих, зөвлөгөө өгөх болон эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
	<p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:</p>	<p>Даатгуулагчийг товлолт хугацаанд урьдчилан мэдэгдсэний, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагатай холбох асуудлыг зохион байгуулах ажил анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ба үүнтэй холбоотой зардлыг анхан шатны нэг иргэнээр тооцсон төлбөрт багтсан тул давхар санхүүжилт олгохгүй.</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийх оношилгоо, шинжилгээний зардлыг ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ. Багцад багтсан оношилгоо, шинжилгээ болон тусламж, үйлчилгээг бүрэн хийлгэсэн байна.</p>	

---oOo---

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц,
төлбөрийн хэмжээ**

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэх эрт илрүүлгийн багц

Эрт илрүүлгийн багцын төрөл	Хийгдэх оношилгоо, шинжилгээ, үзлэг	Насны бүлэг ба эрсдэлт хүчин зүйлс	Төлбөрийн хэмжээ	Код
1. Сургуульд суурилсан эрт илрүүлэг				
1.1. “6 настан”-ы эрт илрүүлэг	Ерөнхий үзлэг	6 настай хүүхэд	*	
	Хэмжилт: Өндөр, жин бүсэлхийн тойрог, Хараа сонсгол			
	Шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө			
	Зүрхний цахилгаан бичлэг ¹			
1.2. “12 настан”-ы эрт илрүүлэг	Ерөнхий үзлэг	12 настай хүүхэд	*	
	Хэмжилт: Өндөр, жин бүсэлхийн тойрог, Хараа сонсгол			
	Хоолны асуумж, зөвлөгөө			
	Шүдний урьдчилан сэргийлэх үзлэг			
1.3. “15 настан”-ы эрт илрүүлэг	Ерөнхий үзлэг	15 настай хүүхэд	*	
	Хэмжилт: Өндөр, жин бүсэлхийн тойрог, Хараа сонсгол			
	Сэтгэлзүйн сорил, зөвлөгөө			
	Сүрьеэгийн эрсдэлийн үнэлгээ			
	ХДХВ илрүүлэх хурдавчилсан шинжилгээ			
Хорт хавдрын эрт илрүүлэг				
1.2. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг	Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах	18-аас дээш нас Өмнө В, С вирус оношлогдоогүй байх		
	В вирус илрүүлэх хурдавчилсан сорил	-18-с дээш нас -Өмнө В вирус оношлогдоогүй байх	3500₮	
	С вирус илрүүлэх хурдавчилсан сорил	-18 дээш нас -Өмнө С вирус оношлогдоогүй байх	6,000₮	

¹ Эрт илрүүлэгт орсон шинжилгээг анхан шатны оношилгоо, шинжилгээтэй давхардуулж санхүүжүүлэхгүй.

*Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн багцаар санхүүжүүлнэ.

** ЭМДҮЗ-өөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.

	В эсвэл С вирус илэрсэн тохиолдолд эмчийн үзлэг хийж, хяналтад аван, дараагийн шатлалд илгээх	Хяналтад авах		
1.3. Улаан хоолой, ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг	Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах	40 дээш насны хүн ам, 2 жил тутам		
	Эрсдлийн үнэлгээ, улаан хоолой ходоодны дуранд илгээх	-Хоол боловсруулах замын зовиуртай -Өмнөх эрт илрүүлгээр ходоодны үрэвсэл, шархлаа илэрсэн	70,000₮	10204003
Лавлагаа шатлалын эмнэлгээс дурангийн шинжилгээний үр дүнг авч бүртгэлийг шинэчлэх				
1.4. Бүдүүн гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг	Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах	45 дээш настай хүн ам, 2 жил тутам		
	Эрсдлийн үнэлгээ	-Гэр бүлд ургацаг, хавдрын асуумжтай -Бүдүүн гэдэсний шархлаа кроноор өвдөж байсан		
	Өтгөнд далд цус илрүүлэх хурдавчилсан сорил	12,000₮	10113009	
	Эрсдэлтэй иргэдийг бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээнд илгээх	70,000₮	10202003	
Дурангийн шинжилгээний хариуг авч бүртгэлийг шинэчлэх				
1.5. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг	Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах	27 насны эмэгтэй ба 45-63 насны эмэгтэйд 3 жил тутам	15,000₮	10108024
	Эсийн шинжилгээ ПАП тестийн сорьц авах			
	ПСР тестийн сорьц авах	30 ба 40 настай эмэгтэй	93,800₮	01080121
Шинжилгээний хариуг авч бүртгэлийг шинэчлэх				
1.6. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг	Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах	40-70 насны эмэгтэй		
	Эрсдлийн үнэлгээ	Эрсдэлд үндэслэн давтамжийг тодорхойлно. Лавлагаа шатлалаас гарсан шинжилгээний хариуг авч бүртгэлийг шинэчлэх		
1.7. Уушигны хорт хавдрын эрт илрүүлэг	Эрт илрүүлэгт хамруулах иргэдийн бүртгэл гарган дуудах	50 дээш настай, 15-аас дээш жил тамхи татсан		
	Эрсдлийн үнэлгээ			
	Лавлагаа шатлалаас гарсан шинжилгээний хариуг авч бүртгэлийг шинэчлэх			

Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад хийгдэх эрт илрүүлэг

Эрт илрүүлгийн багцын төрөл	Хийгдэх оношилгоо, шинжилгээ, үзлэг	Насны бүлэг ба эрсдэлт хүчин зүйлс	Төлбөрийн хэмжээ	Код
-----------------------------	-------------------------------------	------------------------------------	------------------	-----

1. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг	В, вирусын ачаалал үзэх шинжилгээ	В вирусын халдвартай	133,000₮	10108031
	С вирусын ачаалал үзэх шинжилгээ	С вирусын халдвартай	139,000₮	10108035
	Хэвлийн хэт авиа	-Циррозтой	15,000₮	10203002
	Элэгний үйл ажиллагаа: Биохими /АСАТ, АЛАТ, шууд билирубин/	-В,С вирусын идэвхижил өндөр	9,000₮	10102003, 10102010, 10102015
	Цусанд АФП үзэх	-Элэгний хорт хавдрын удамтай	20,000₮	1006237
	Эмчийн үзлэг, хяналт зөвлөгөө			
2. Ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг	Улаан хоолой, ходоодны дуран	40 дээш насанд 2 жил тутам	70,000₮	10202003
	Улаан хоолой ходоодны дуран ба эдийн шинжилгээ	Мэргэжлийн эмчийн заалтаар	70,000₮ 22,000₮	10202003, 10106228
	Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө	Эмч шинжилгээнд үндэслэн давтамжийг тодорхойлох		
3. Бүдүүн гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг	Бүдүүн гэдэсний дуран	45-аас дээш насанд 2 жил тутам -Гэр бүлд ургацаг, хавдрын асуумжтай -Бүдүүн гэдэсний шархлаа кронуор өвдөж байсан	70,000₮	10202003
	Бүдүүн гэдэсний дуран, эдийн шинжилгээ	Эмчийн заалтаар	70,000₮ 22,000₮	10202003, 10106228
	Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө	Эрсдэлд үндэслэн давтамжийг тодорхойлох		
4. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг	Хүний папилома вирусын шинжилгээ	30 ба 40 настай эмэгтэй	58,000₮	10108025
	Умайн хүзүүний эсийн шинжилгээ	27 насны эмэгтэй ба 45-63 насны эмэгтэйд 3 жил тутам	32,000₮	10101003
	Кольпоскопи хийх	Хүний папилома вирусын шинжилгээнд эерэг, эрсдэл өндөртэй эмэгтэйд эмчийн заалтаар	30,000₮	10201008
	Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө			
5. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг	Хөхний хэт авийн шинжилгээ	40-70 насны эмэгтэйд 2 жил тутам	15,000₮	10203002
	Маммографи	Хөхний эхоны хариунд үндэслэн эмчийн заалтаар хийх	35,000₮	102140051

	Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө			
6. Уушигны хорт хавдрын эрт илрүүлэг	Бага тунт компьютер томографи	50 дээш настай, 15-аас дээш жил тамхи татсан	120,000₮	10211003
	Мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө	Эрсдэлд үндэслэн давтамжийг тодорхойлох		